


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр **7,372.4** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс

39.4 хувь буюу **2,084.1** сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл **850.2** сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	6,340.5	6,832.8	5,288.3	7,372.4	2,084.1	39.4
-Экспорт	3,581.4	3,939.0	2,828.2	4,111.3	1,283.1	45.4
-Импорт	2,759.1	2,893.8	2,460.1	3,261.1	801.0	32.6
Тэнцэл	822.2	1,045.2	368.0	850.2	482.2	131.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2021 оны эхний хагас жилийн байдлаар гадаад худалдааны тэнцэл **850.2** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс **482.2** сая ам.доллар буюу **2.3** дахин өсөхөд импорт **801.0** сая ам.доллар, экспорт **1,283.1** сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Экспорт: Экспортын худалдаа 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр **4,111.3** сая ам.долларт хүрч, эдийн засаг хэвийн байсан үе буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад **172.3** сая ам.доллар буюу **4.4**

хувийн өсөлттэй байна. Харин 2020 оны мөн үеэс **1,283.1** сая ам.доллар буюу **45.4** хувиар өссөн байна.

Импорт: 2021 оны эхний хагас жилийн байдлаар импортын хэмжээ **3,261.1** сая ам.доллар болж 2019 оны мөн үетэй харьцуулахад **367.3** сая ам.доллар буюу **12.7** хувиар, 2020 оны мөн үеэс **801.0** сая ам.доллар буюу **32.6** хувиар өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **82.4** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **17.6** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **3,389.4** сая ам.долларт хүрч, өмнөх оноос **1,368.8**

сая ам.доллар буюу **67.7** хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **721.9** сая ам.доллар болж, өмнөх оноос **85.7** сая ам.доллар буюу **10.6** хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	3,027.0	3,307.5	2,020.6	3,389.4	1,368.8	67.7	82.4
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	554.4	631.5	807.6	721.9	-85.7	-10.6	17.6
Нийт экспорт	3,581.4	3,939.0	2,828.2	4,111.3	1,283.1	45.4	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 31.9 хувийг зэсийн баяжмал, 24.7 хувийг нүүрс, 13.4 хувийг төмрийн хүдэр ба баяжмал, 5.3 хувийг боловсруулаагүй алт, 4.1 хувийг

боловсруулаагүй нефть, 2.5 хувийг цайрын хүдэр ба баяжмал, 2.1 хувийг жоншны хүдэр эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	733.7	749.2	675.9	614.9	-61.0	-9.0
Нүүрс	сая.тн	18.0	18.0	8.7	9.3	0.6	7.2
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	3.4	4.1	4.1	4.0	-0.1	-2.3
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	61.6	72.4	66.6	66.7	0.0	0.1
Алт	тн	3.4	4.7	11.0	3.7	-7.3	-66.7
Боловсруулаагүй нефть	сая.баррель	3.3	3.2	1.0	2.9	1.9	200.5
Катодын зэс	тн	7.0	4.6	5.7	5.8	0.0	0.7
Адууны мах	мян.тн	8.9	9.8	2.8	7.1	4.2	150.2
Өлөн гэдэс	тн	214.9	211.7	276.0	292.5	16.5	6.0

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	51.6	43.7	21.4	5.9	-15.5	-72.5
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.3	229.6	28.4	441.4	413.0	1,454.2
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	69.6	36.9	35.7	66.2	30.5	85.5
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	89.9	97.1	74.1	63.4	-10.8	-14.5
Самнасан ноолуур	тн	171.4	155.1	104.6	152.8	48.2	46.1
Бохир ноолуур	тн	3,974.1	4,207.6	2,656.7	4,893.2	2,236.5	84.2
Хонины самнаагүй ноос	мян.тн	3.3	4.8	2.7	5.5	2.9	107.2
Жоншны баяжмал	мян.тн	196.0	286.4	313.7	391.0	77.3	24.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	1,014.0	1,062.4	741.1	1,312.9	571.8	77.2
Нүүрс	1,404.8	1,540.5	690.1	1,017.0	327.0	47.4
Төмрийн хүдэр	156.1	251.8	283.2	550.8	267.6	94.5
Цайрын баяжмал	108.0	107.1	80.1	101.1	21.0	26.3
Алт	144.5	195.9	606.4	218.0	-388.4	-64.0
Боловсруулаагүй нефть	212.4	179.7	34.0	168.4	134.4	395.7
Катодын зэс	46.8	27.3	30.8	50.6	19.9	64.6
Адууны мах	19.5	18.5	5.6	14.6	9.1	163.6
Өлөн гэдэс	3.8	4.3	4.4	6.7	2.3	51.3
Үхэр, адууны боловсруулсан шир	5.7	4.7	2.0	0.7	-1.3	-65.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.01	0.7	0.1	0.7	0.7	1301.3
Хонь, хурганы боловсруулсан арьс	2.0	0.9	0.9	1.3	0.4	49.2
Ямаа, ишигний боловсруулсан арьс	3.4	3.2	2.7	1.8	-0.9	-33.8
Самнасан ноолуур	14.3	14.2	7.7	11.6	3.9	51.6
Бохир ноолуур	187.6	216.1	78.3	197.1	118.8	151.8
Хонины самнаагүй ноос	4.0	7.4	2.8	5.7	2.9	105.6
Жоншны баяжмал	64.3	92.8	75.7	84.8	9.1	12.0
Нийт экспортод эзлэх хувь	94.7%	94.6%	93.5%	91.1%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс **1,368.8 сая** ам.доллар буюу 67.7 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1. Нүүрс: 2021 оны эхний хагас жилийн байдлаар **9.3** сая тонн нүүрс экспортлож, **1,017.0** сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын орлого 327.0 сая ам.доллараар буюу 47.4 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 37.9 хувиар өссөн болон тоо хэмжээ 1.1 дахин нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлого өсөхөд нөлөөлжээ.

2. Зэсийн баяжмал: 2021 оны эхний хагас жилийн байдлаар зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 77.2 хувь буюу 571.8 сая ам.доллараар нэмэгдэж, **1,312.9** сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ **614.9** мянган тонн болж өнгөрсөн оны мөн үеэс 9.0 хувь буюу 61.0 мянган тонноор буурсан боловч экспортын дундаж үнэ нь 94.7 хувиар өссөн байна.

3. Цайрын баяжмал: 2021 оны эхний хагас жилийн байдлаар цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ **66.7** мянган тоннд хүрч, **101.1** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 26.3 хувь буюу 21.0 сая ам.доллараар өсөхөд цайрын баяжмалын биет хэмжээ 0.1 хувь буюу 0.05 мянган тонноор өссөн боловч нэг тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 26.0 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

4. Төмрийн хүдэр: 2021 оны эхний хагас жилийн байдлаар төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ **4.0** сая тонн болж, **550.8** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 94.5 хувь буюу 267.6 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 2.3 хувь буюу 0.1 сая тонноор буурсан боловч нэг тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 99.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Экспортод нөлөөлсөн хүчин зүйлс: Чулуун нүүрсний экспорт 9.3 сая тоннд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 7.2 хувийн өсөлттэй гарсан. 2021 онд дэлхийн эдийн засаг, ялангуяа БНХАУ-ын эдийн засаг сэргэж байгаа нь уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт тогтвортой байж, энэ он дуустал үнэ өндөр хэвээр хадгалагдах хүлээлтийг бий болгож байгаа гэж гаалийн байгууллага дүгнэж байна. Гэвч Коронавируст халдварын тархалт дотоодод удаан үргэлжлэх, уул уурхайн голлох бүсүүдэд халдварын тархалт нэмэгдэх зэргээс шалтгаалан эрдсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ төсөөлснөөс буурах эрсдлээс сэргийлэх шаардлагатай юм.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын **16.9** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **83.1** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **551.9** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс **66.5** сая ам.доллараар буюу 13.7 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **2,709.2** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс **734.4** сая ам.доллар буюу 37.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Эрдсийн бүтээгдэхүүний импорт
/сая ам.доллар/

Үзүүлэлт	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	591.1	621.9	485.4	551.9	66.5	13.7	16.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	2,168.0	2,271.9	1,974.8	2,709.2	734.4	37.2	83.1
Нийт импорт	2,759.1	2,893.8	2,460.1	3,261.1	801.0	32.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд авто, агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 21.7 хувь, машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэгийн импорт 17.7 хувь, эрдэс бүтээгдэхүүний импорт 16.9 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйлийн импорт 15.2 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүний импорт 8.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр
/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2020.06	2021.06	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	37.7	63.5	25.9	68.7	1.9
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	65.9	126.5	60.6	91.9	3.9
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	19.0	25.8	6.7	35.2	0.8
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	197.7	278.9	81.1	41.0	8.6
5	Эрдэс бүтээгдэхүүн	485.4	551.9	66.5	13.7	16.9
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	173.0	270.5	97.4	56.3	8.3
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс	100.7	116.9	16.2	16.1	3.6
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	2.4	3.0	0.6	23.2	0.1
9	Мод, модон эдлэл	23.2	22.2	-1.0	-4.4	0.7
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	27.1	31.3	4.1	15.3	1.0
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	40.5	45.6	5.2	12.8	1.4
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	7.9	10.2	2.3	29.0	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	68.2	76.1	7.9	11.6	2.3
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	0.6	3.1	2.4	381.0	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	235.6	247.1	11.5	4.9	7.6
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	526.4	576.6	50.3	9.5	17.7
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	374.1	708.7	334.6	89.4	21.7
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг тэдгээрийн эд анги	39.6	59.3	19.7	49.8	1.8
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	34.4	41.7	7.3	21.2	1.3
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.02	0.1	0.1	443.1	0.004
	ДҮН	2,460.1	3,261.1	799.4	32.5	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортод нөлөөлсөн хүчин зүйлс: Эдийн засгийн нөхцөл байдал эргэн сэргэж нийт импорт 3,261.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 32.5 хувиар өссөн. Гэвч БНХАУ-ын талаас хилээр нэвтрүүлэх ачааны машины тоонд хязгаарлалт хийж байгаагаас импортын барааны татан авалтад доголдол үүсгээд байна гэж гаалийн байгууллага үзэж байна. УОК-ын даргын энэ оны 6 дугаар сарын 08-ны өдрийн тушаалаар Коронавируст цар тахлын улмаас удааширч буй Замын-Үүд-Эрээн чиглэлийн улс хоорондын ачаа тээврийн эргэлтийг эрчимжүүлэхээр ажиллаж байна.

Тодруулбал, БНХАУ-ын Тяньжин боомтод Монгол Улс руу ирэхээр хүлээгдэж буй чингэлгийн эрчмийг сайжруулах, тээвэрлэлтэд үүсэж буй хүндрэл саатлыг арилгах, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Шуурхай бүлгийг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан байгуулсан. ГХЯ, ЗТХЯ, МХЕГ, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын холбогдох хүмүүсээс бүрдсэн Шуурхай бүлгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд БНХАУ-ын Тяньжин боомтод саатаж байсан 3162 чингэлгийн эхний ээлжийн 943 чингэлгийг Замын-Үүд өртөөнд хүлээн авсан байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны хилийн Эрээн өртөөнөөс 6 дугаар сарын 09-17-ны өдрүүдэд импортын чингэлгийн 18 галт тэрэг орж ирсэн байна. Ингэснээр энэ оны 6 дугаар сарын 08-ны өдөр хүртэл Тяньжин боомтоос хоногт импортын чингэлгийн 1 галт тэрэг хуваарийн дагуу тогтмол ирдэг байсныг 2 дахин нэмэгдүүлжээ.

Мөн Эрээн өртөөнөөс автомашинаас вагонд шилжүүлэн ачсан 125 вагон ачаа орж ирснийг /6 дугаар сарын 16-нд 41 вагон, 17-нд 33 вагон г.м/ өмнөх сартай харьцуулахад тээвэрлэлт 2 дахин нэмэгдээд байгааг ЗТХЯ мэдээлсэн байна.

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага 2021 оны эхний эхний хагас жилд нийт **1,718.5** тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс **1,643.5** тэрбум төгрөгийг төвлөрүүлж гүйцэтгэл 95.6 хувьтай байна.

Хүснэгт 7. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2020.06		2021.06		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	гүйц.	төлөв.	гүйц.	зөрүү	хувь	зөрүү	хувь	
Нийт орлого	1,337.6	1,718.5	1,643.5	305.9	122.9	-75.0	95.6	
Гаалийн албан татвар	335.7	445.5	441.3	105.6	131.5	-4.2	99.1	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	700.6	910.1	883.0	182.4	126.0	-27.1	97.0	
Архи, дарсны онцгой албан татвар	3.8	5.6	8.4	4.6	219.7	2.8	149.9	
Тамхины онцгой албан татвар	53.1	62.9	64.4	11.3	121.3	1.5	102.4	
Шар айрагны онцгой албан татвар	1.0	0.9	2.1	1.1	209.0	1.2	232.2	
Суудлын автомашины онцгой албан татвар	89.5	100.2	94.9	5.4	106.0	-5.3	94.7	
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	121.0	140.9	117.4	-3.6	97.0	-23.5	83.3	
Автобензин, дизель түлшний албан татвар	8.0	8.9	6.5	-1.5	81.3	-2.4	73.0	
Экспорт	0.008	0.004	0.024	0.016	0.0	0.0	600.0	
Татварын Дүн	1,312.7	1,675.0	1,618.0	305.3	123.3	-57.0	96.6	
Өөрийн орлого	3.1	9.9	2.6	-0.5	84.8	-7.2	26.7	
Хураамж	21.8	33.7	22.9	1.1	105.0	-10.8	67.9	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого **305.9** тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Гаалийн албан татвар **105.6** тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар **182.4** тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар **4.6** тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар **11.3** тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар **1.1** тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар **5.4** тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин автобензин, дизель түлшний онцгой албан татвар 3.6 тэрбум төгрөг, автобензин, дизель түлшний албан татвар 1.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тав. Татварын чөлөөлөлт

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээр **1,141.7** тэрбум төгрөг буюу нийт импортын **12.3** хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт **1,947.6** тэрбум төгрөгөөр буюу **31.4** хувиар, татвараас чөлөөлөгдсөн

импорт **438.6** тэрбум төгрөгөөр буюу **62.4** хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **2.1** нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2020.06	2021.06	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	6,193.2	8,140.8	1,947.6	131.4%
Эзлэх хувь	89.8%	87.7%	-2.1%	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	703.1	1,141.7	438.6	162.4%
Эзлэх хувь	10.2%	12.3%	2.1%	
Нийт импорт	6,896.2	9,282.5	2,386.2	134.6%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2021 оны эхний хагас жилд 1,141.7 тэрбум төгрөгийн импортын бараанд ногдох **189.8** тэрбум төгрөгийн татвар чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 69.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламжийн хүрээнд 68.1 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **10.6** тэрбум төгрөг;
2. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016.09.07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-иар 130.9 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **34.7** тэрбум төгрөг;
3. Иргэний агаарын тээврийн зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг 69.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **10.5** тэрбум төгрөг;
4. Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг зэрэг 7.1 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **1.1** тэрбум төгрөг;
5. Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 146.5 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **25.0** тэрбум төгрөг;
6. Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос зэрэг 320.6 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **48.9** тэрбум төгрөг;

7. Бусад төрлийн барааны хувьд татварын холбогдох хуулийн зүйл, заалтуудаар 332.2 тэрбум төгрөгийн бараанд ногдуулсан **50.7** тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Хүснэгт 9. Татварын чөлөөлөлт

/тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2020.06		2021.06		Өөрчлөлт (2021/2020)	
		үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар
1	Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос	155.0	24.0	320.6	48.9	165.6	24.9
2	Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	239.7	52.3	130.9	34.7	-108.8	-17.6
3	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	20.1	2.9	68.1	10.6	48.0	7.7
4	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	18.8	3.0	69.7	10.5	50.9	7.5
5	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын зээл	118.9	17.6	146.5	25.0	27.6	7.4
6	Хийн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж	30.7	4.8	29.6	4.6	-1.1	-0.2
7	Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	4.0	0.5	7.1	1.1	3.1	0.6
8	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	35.1	3.5	37.0	3.7	1.9	0.2
9	Бусад	80.8	12.2	332.2	50.7	251.5	38.5
	Дүн	703.1	120.8	1,141.7	189.8	438.6	69.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлж байгаа татварын чөлөөлөлтийн арга хэмжээ:

Дэлхий нийтэд тархаад байгаа коронавируст халдвар (COVID 19)-ын дэгдэлттэй холбоотойгоор гаргасан шийдвэрүүдийг үндэслэн гаалийн байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

1. 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан “Бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг гаалийн албан татвар болон НӨАТ-аас чөлөөлөх тухай” хуулийн хүрээнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 195 аж ахуйн нэгж, 1 хувь иргэний импортолсон нийт 111.6 сая ам.доллларын нэр төрлийн бараанд ногдох 48.5 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлсөн байна.

2. Коронавируст халдварын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг дараах хууль тогтоолын дагуу татвараас чөлөөлөх тухай чиглэл өгснөөр дараах хууль, тогтоолуудын хэрэгжүүлж ажиллажээ. Үүнд:

- Засгийн газрын 2009 оны 335 дугаар тогтоол /томуугийн А хүрээний (H1N1) вирусийн оношилгоо, эмчилгээний/;

- Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр батлагдснаар дагаж гарсан Засгийн газрын 132-р тогтоолын хүрээнд тус тус эхний хагас жилийн байдлаар 160 аж ахуйн нэгжийн импортолсон нийт 103.7 сая ам.доллларын нэр төрлийн бараанд ногдох 45.6 тэрбум төгрөгийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлсөн байна.

3. Цар тахлын үед хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд татварын дэмжлэг үзүүлэх, дотоодын хүнсний үйлдвэрлэл, тогтвортой нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн шинэ трактор комбайн, тоног төхөөрөмжийг энэ оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс он дуустал гаалийн албан татвараас хөнгөлж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийг хэрэгжүүлж эхэлснээр 2021 оны эхний хагас жилийн байдлаар 72 аж ахуйн нэгж, 4 хувь иргэний импортолсон нийт 12.9 сая ам.доллларын бараанд ногдох 3.7 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлсөн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС